

Мосе Египетийн хааны ордонд өсч хүмүүжсээр нэг л мэдэхэд нас биед хүрсэн байв.

Мосе, Египетчүүдэд боолчлогдон дарамтлагдаж байгаа Израильчуудыг хараад сэтгэл нь ихээр өвддөг байжээ.

Нэг өдөр, Мосе египетчүүдийн ажилладаг газраар өнгөрч явтал тэнд нэгэн Египет хүн Израиль хүнийг хэрцгийгээр зодож байхыг харчихав.

Мосе өөртэй нь адил Еврей хүн бусдад зодуулж байхыг хараад ихэд уур нь хүрч байлаа.

Тэгээд тэр тэсэлгүй өнөөх Египет хүнийг зохиод алчихав.

Мосе Египет хүнийг хөнөөсөн тухай сураг чимээ ордон хүртэл тархаж орхив.

Фараон хаан энэ мэдээг сонсоод Мосег бушуу хайж олоод алах гэж байв.

Мосе, өөрийг нь хөнөөх гэж байгаа Египет цэргүүдээс зугтаж Мидианы цөл рүү явав.

Ингээд Мосе цөлд хонь хариулан амьдардаг хоньчин болов.

Тэрээр Египетэд ханхүү байснаа мөн Израильчуудын боолчлогдон байгааг бага багаар мартаж байлаа.

Мосе нэгэн өдөр хонио хариулсаар Хороб уулан дээр гарав.

Гэтэл тэр газарт үнэхээр хачирхалтай нэгэн зүйлийг олж харав.

Ингэж хачин зүйлийг харахдаа зэрэгцэн Бурханы дуу хоолой сонсогдож байв.

Мосе үнэхээр их айсандаа сөхөрч унан нүүрээ нув.

Бурхан түүнд, “Мосе~ Миний ард түмэн Египет зовж шаналж байгааг Би олж харлаа, тэдний зовж шаналсан дуу хоолойг ч сонслоо. Одоо Би чамайг Фараон уруу явуулах тул чи Миний ард түнийг Египетээс авч гарах ёстой.”

Үүнийг сонссон Мосе маш их айв.

Түүнийг сайн ойлгож байсан Бурхан, Мосед “Би чамтай хамт байх болно.” гэж хэлэв.

Бас Мосед туслуулахаар үг хэлэндээ маш сайн түүний ах Аароныг Бурхан бэлдсэн байлаа.

Ингээд Мосе болон Аарон нар Египетийн хаан Фараон уруу очив.

Мосе Фараон хаанд ингэж хэлэв:



“Израиль ард түмнийг Бурханд үйлчлүүлэхээр цөл рүү илгээж өгнө үү.”

Харин Фараон хаан Израиль ард түмнийг байнга боолчлохыг хүсэж байсан учраас тэднийг явуулахыг хүсэхгүй байлаа.

Энэ явдлаас болж Фараон хаан, Израиль ард түмнийг бүр илүү ихээр дарамталж зовоож байв.

Үүнийг харсан Бурхан ихэд уурлав.

Бурхан уур хилэнгээ Египетийн дээр буулгахдаа тэр газрын бүх голын усыг цус болгосон юм.

Үүнээс болж Египетчүүд уух үсгүй болов.

Фараон хаан хаашаа ч хөдлөх боломжгүй шахагдаж байлаа.

Бурхан Египетчүүдийн дээр бүр их гамшигийг буулгав. Мэлхийн гамшиг, дэлэнчийн гамшиг, бөөн ялааны гамшиг, малын тахалт гамшиг, буглаат хатгины гамшиг, аянга мөндөрийг гамшиг, царцааны гамшиг, түнэр харанхуйн гамшиг ...

Гэсэн ч Фараон хаан Израиль ард түмнийг явуулахгүй хэвээр байлаа.

Тиймээс эцэст нь Бурхан арав дахь гамшигийг буулгав.

Арав дахь гамшигаар Египетэд төрсөн ууган бүхэн үхсэн юм.

Фараон хааны ууган хүү хүртэл нас барсан юм.

Фараон хаан яах ч аргагүй болсон тул Израиль ард түмнийг тавьж явуулжээ.

Ингэж нэг юм эцэст нь Израиль ард түмэн Мосег даган Египетийг орхин гарч явсан юм.

- Дараах библийн эшлэлийг дагаж бицээд цээжлээрэй. (Гэтлэл 3:10)

Өөрийн ард түмэн болох Израилийн
хөвгүүдийг Египетээс авчруулъя гэв.



Үйл ажиллагаа 1.

Өнгийн цаасыг урж, гал дүрэлзэж буй бутыг бүтээгээрэй.
(Хэрэглэгдэх материал: Өнгийн цаас, цавуу)



